

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ АЖЛЫН ХЭСГИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.07.27

ЛҮН

ЗДТГ-ын ХААТасгийн хүнс, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хариуцсан мэргэжилтэн С.Оюунтүлхүүр: Сайн байцаана уу та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 4.3, 7.4 дахь заалт, СИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тогтоол, Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр Хяналтын хороо ажиллахаар цуглараад байна.

Та бүхэндээ СИТХурлын 16 дугаар тогтоолоор батлагдсан хяналтын хорооны бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Хяналтын хорооны дарга Х.Мөнхбаатар / СИТХ-ын цөөнхийн бүлгийн төлөөлөл/

Нарийн бичиг С.Оюунтүлхүүр / ХЖДҮҮХоршоо хариуцсан мэргэжилтэн /
Хяналтын хорооны гишүүн Э.Буянтогтох / Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн/

Хяналтын хорооны гишүүн Г.Батсүх /аймгийн ХХААГ-ын жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн/

Хяналтын хорооны гишүүн Б.Цэцэгээ / Говьсүмбэр аймаг дахь ХАҮТанхимын дарга/ гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй.



Ингээд Хяналтын хорооны дарга Х.Мөнхбаатар хурал удирдана. Хяналтын хорооны дарга Х.Мөнхбаатар: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Хяналтын хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй бүгд 100 хувь цугларсан байна. Хурлыг сумын ЗДТГ-ын 1 дүгээр давхарт байрлах Иргэний танхимд 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 10⁴⁵ цагт эхлүүлж байна. Тэгэхээр хууль, журмын дагуу хяналтын үйл ажиллагааг чанартай, үр өгөөжтэй зохион байгуулах нь зүйтэй байх.

Нарийн бичгийн дарга хуулийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “ Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” ,журмын дагуу нууцын гэрээг тус тус байгуулж ажлаа эхлэе.

11¹⁰ цагт бүгд мэдэгдэл, нууцын гэрээгээ хийж дуусгалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс ажиллахад татгалзах гишүүн байхгүй байна. Бүгд нууцын гэрээ